



Байгаль Орчныг Хамгаалахад Талуудын Оролцоог Нэмэгдүүлэх нь



ESEC II ТӨСЛИЙН ГОЛ ҮР ДҮНГЭЭС (2013-2016)

Азийн сангаас Швейцарийн Хөгжлийн Агентлагийн санхүүгийн дэмжлэгтэйгээр Уул Уурхайн Яамтай хамтран хэрэгжүүлж буй “Байгаль орчныг хамгаалахад талуудын оролцоог нэмэгдүүлэх нь-II (ESEC-II) төслийн хэрэгжих хугацаа 2016 оны 08 дугаар сард дуусгавар болж байна.

Бичил уурхайн байгаль орчны сайн туршлагыг бий болгон нэвтрүүлж, орон нутгийн тогтвортой хөгжилд бичил уурхайчдын оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх хэмээх зорилгоо хэрэгжүүлэхдээ ESEC II төсөл нь сумдын удирдлага болон Олон талт зөвлөлөөр дамжуулан байгаль орчны менежментэд талуудын оролцоо, хамтын ажиллагааг бүрдүүлэхийг чухалчилж, үйл ажиллагаа, арга барил бүртээ хүний эрх, тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын үндсэн зарчимуудыг тусгаж, баримталсан.

Ийнхүү өнгөрсөн гурван жилийн хугацаанд талуудын оролцоог хангаж чадсаны үр дүнд бичил уурхайчдын байгууллага, орон нутгийн удирдлага, нутгийн иргэд хоорондын хамтын ажиллагааны боломжит арга хэлбэр, бичил уурхайн байгаль орчны асуудлыг шийдвэрлэх гарц, арга хэрэгсэлүүдийг боловсруулж, өдгөө хэрэгжүүлж байна.

БИЧИЛ УУРХАЙН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН АРГАЧЛАЛ- АСУУДЛИЙН ШИЙДЭЛ

2014-2015 онд хэрэгжүүлсэн Бичил уурхайн нөхөн сэргээлтийн загвар 17 төслүүдийн туршлага, үр дүнд тулгуурлан Бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалыг боловсруулж, бичил уурхайгаар ашигт малтмал олборлох тухай 308 дугаар тогтоолын хавсралт болгон албажуулахаар ажиллаж байна. Ингэснээр бичил уурхайчид нөхөн сэргээлтийг хямд төсөр, олон нийт хүлээн зөвшөөрөхүйц, байгаль экологид ээлтэй аргаар хэрэгжүүлэх боломжтой болж байна. Аргачлалд бичил уурхайгаар эвдэрч, орхигдсон газруудын техник болон биологийн нөхөн сэргээлтийн үе шат бүрийг дэлгэрэнгүй тайлбарласанаас гадна нөхөн сэргээх талбайг хүлээн авах Хяналтын хуудас, Бичил уурхайн нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний загварыг тус тус хавсаргасан. Ийнхүү аргачлалын дагуу нөхөн сэргээлт хийх, орон нутгаас нөхөн сэргээлтийн явц, үр дүнд хяналт тавих хэрэгсэлийг бий болгосоноор холбогдох талууд хамтын оролцоотойгоор байгаль хамгаалах үйлсэд нэгдэх боломжтой болж, улмаар нөхөн сэргээлтийг гар аргаар ашигт малтмал олборлосоны улмаас эвдэрсэн бусад газарт түгээн дэлгэрүүлэх боломжийг бүрдүүлээ.

Төслийн хүрээнд Бичил уурхайн нөхөн сэргээлтийн 17 загвар төслүүдийн эмхэтгэлийг боловсруулсан бөгөөд үүнд 2014-2015 экологийн хувь ялгаатай бүс нутгуудад хэрэгжүүлсэн нөхөн сэргээлтийн туршлагауд, холбогдох зөвлөмжүүдийг нэгтгэн оруулсан юм. Ингэснээр орон нутгийн удирдлага, бичил уурхайчид болон бусад талууд хамтран нөхөн сэргээлтийг түгээн дэлгэрүүлэн хэрэгжүүлэх боломжтой байгаа юм.



БИЧИЛ УУРХАЙН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Бичил уурхайн нөхөн сэргээлтийн төлөвлөгөө боловсруулах сургалтуудыг Хариуцлагатай уул уурхайн санаачлага, Бичил уурхайн эрхлэгчдийн нэгдсэн дээвэр холбоо, “Эрин үе – экологи хөгжил” сургалтын төвийн сургагч багш нараар дамжуулан зохион байгууллаа. Бичил уурхайн нөхөрлөл, ТББ нь ийм төлөвлөгөөтэй болсоноор нөхөн сэргээлтийг батлагдсан аргачлалын дагуу хэрэгжүүлж, СБОМТ-ний хэрэгжилтэнд хувь нэмэр оруулж, цаашид хууль ёсны дагуу бичил уурхайн зориулалтаар газар авч, хариуцлагатай бичил уурхайг хэрэгжүүлж чадахаа үлгэрлэн харуулах боломжтой болж байгаа юм. Төлөвлөгөөний загварыг өмнө нь эвдэрч орхигдсон, одоо олборлож буй, цаашид олборлохоор төлөвлөж буй газрыг нөхөн сэргээх гэсэн гурван үндсэн зорилгоор боловсуулж болохоор хийсэн тул бичил уурхайчид аргачлалыг ашиглах, уурхайн олборлолтын мөчлөгт суурилсан хандлагыг хэрэгжүүлж хэвших юм.

НОГООН АЖЛЫН БАЙР БИЙ БОЛГОХ

Нийт 3 байршилд нутгийн ургамал үржүүлгийн газрыг байгуулахад дэмжлэг үзүүлэх замаар ногоон ажлын байр бий болгож, уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орж, доройтсон газрын биологийн нөхөн сэргээлтэнд ашиглах нутгийн ургамалын нөөцийг орон нутагт бий болгож, бичил уурхайчдын амжиргааны эх үүсвэрийг нэмэгдүүлэхийг зорьж байна. Энэхүү санаачлагыг аймаг, сумд болон хэрэгжүүлэгч бичил уурхайн байгууллагатай Санамж бичгийн хүрээнд хэрэгжүүлж байгаа нь мөн л хамтын ажиллагаа,

Төслийн үр дүнд бий болсон бүтээгдэхүүн, хэрэгсэлийг цаашид залгамжлан, илүү өргөн хүрээний үр нөлөө гарган хэрэгжүүлэх бүрэн боломжтой юм. Бид энэхүү залгамж чанарыг алдагдуулахгүйн тулд төслийн амжилт, сайн туршлагыг хамтран ажиллаж ирсэн УУЯ, АМГ, бусад төрийн байгууллага болон ШХА-гийн ТБУ төсөлд хүлээлгэн өгөх санаачлагыг эхлүүлж байна.

СУМЫН БАЙГАЛЬ ОРЧИН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ

Байгаль орчны гол оролцогч талуудыг татан оролцуулах замаар байгалийн нөөцийн зүй зохистой, тогтвортой ашиглалтыг бий болгох зорилгоор төслийн хүрээнд Сумын байгаль орчны менежментийн төлөвлөгөөг (СБОМТ) боловсруулах санаачлалыг хэрэгжүүлж байна. Одоогийн байдлаар нийт 21 сумаас 3 сум байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөө боловсруулж, ИТХ-аар батлуулаад байна. СБОМТ боловсруулах нь байгаль орчны төлөвлөлтөнд иргэдийн оролцуулсан шинэлэг үйл явц юм. СБОМТ-нд сумын эдийн засгийн голлох үйл ажиллагаанууд, тэдгээрээс үүсэх байгаль орчны нөлөөлөл, байгалийн нөөц ашиглагч оролцогч талуудын харилцаа ба үүрэг хариуцлага, хэрэгжүүлэх шаардлагатай хамгааллын арга хэмжээ, мөн тайлагнах болон хяналт үнэлгээ хийх үйл явц зэргийг тодорхойлж тусгасан.

ТӨСЛИЙН ХААЛТ

ESEC II төслийн Хаалтын үйл ажиллагааны үеэр ололт амжилтаа талуудад тайлагнахын сацуу хамтран ажилласан талууд болон түнш байгууллагуудад хандан бичил уурхайн байгаль орчны асуудлыг шийдвэрлэж, хамтын оролцоо бүхий байгаль орчны менежментийг бий болгоход чиглэсэн хүчин чармайлт, үр дүнг хэрхэн үргэлжлүүлэн хэрэгжүүлэх тухай хэлэлцэж, зөвлөмжийг танилцуулах юм.

Азийн Сан нь ашгийн бус, төрийн бус, олон улсын хөгжлийн байгууллага бөгөөд АНУ-ын Сан Франциско хотод төвтэй, Азийн 18 орон болон АНУ-ын Вашингтон Ди Си хотод салбаруудтай. Төр, хувийн хэвшил, олон нийтийн байгууллагуудтай хамтран засаглал, эдийн засгийн хөгжил, эмэгтэйчүүдийг чадавхижуулах, байгаль орчныг хамгаалах, бүс нутгийн хамтын ажиллагааг дэмжих зэрэг чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна.

 Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development
and Cooperation SDC
Швейцарийн хөгжлийн агентлаг

 The Asia Foundation
Improving Lives, Expanding Opportunities

ТӨВ БАЙР

465 Калифорни гудамж,
9-р давхар, Сан
Франциско хот, СА
94104 АНУ
Утас (415) 982-4640
Факс: (415) 392-8863

Монгол дахь суурин
төлөөлөгчийн газар
Ориент Плаза, 3-р давхар
Г.Чагдаржавын гудамж
Төв шуудан, ш/х 1003
Улаанбаатар хот, 14210
Монгол улс